

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Далхаа	Дугаар	L152
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Баянбулаг
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сангийн далайн хийд, Бугатын хийд, Хадатын хийд	Сүм хийдийн дугаар	БХББ 081, БХББ 079
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 16	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Наран хутагтын хийд буюу Сангийн далай хийд, Бугатын хийд, Хадатын хийд

Асуулт:- Та тус сумын нутагт орших Наран хутагтын хийд буюу Сангийн далай хийдийн тухай бидэнд ярьж өгнө үү. Анх ямар хүн үүсгэн байгуулсан, хэдэн онд байгуулагдсан юм бол? Ер нь Наран хутагтын хийд хичнээн ламтай хийд байсан юм бол?

Хариулт:-Ямар ч байсан 100 гаруй ламтай байсан гэсэн. **Наран гэгээн** анх газрыг нь үзэж шинжиж тогтоогоод тэгээд тэнд хийдээ барьсан гэдэг юм.

Асуулт:-Хэдэн онд байгуулагдсан юм бол, нэлээн дээхнэ үед үү?

Хариулт:-Ер нь нэлээн дээр үед гэсэн шүү.

Асуулт:-Хичнээн тооны дугантай, ямар ямар дугантай байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Ямар ч байсан 10 гаруй дугантай байсан гэнэ лээ, чухам би яг тийм тийм дугантай байсан гэдгийг тодорхой сайн мэдэхгүй байна.

Асуулт:-Хийдийн мяндагтан, дээд тушаалын ямар лам нар байсан бэ? тэргүүн нь хэн байсан, унзад гээд? Нэрийг нь мэдэх хүн байгаа юу?

Хариулт:-Мэдэхгүй.Наран гэгээний эцэг **Дашширчин** гэж хүн байсан юм гэнэ лээ. Тэр их хувилгаан хүн байсан гэнэ лээ. Хүү нь 3 настай хойд хүрээнд залагдаж байсан гэж ярьдаг юм байна лээ. Уг нь энэ Наран гэгээний гэр бүлийнх хошуунд бага шиг үлсүүд манай энд нүүж ирж энд Наран гэгээн хүрээнийхээ газрыг үзэж шинжээд тэгээд энд хүрээ барина гэж шийдээд, тэгээд хүрээ барьсан гэдэг юм.

Асуулт:-Хийд барихдаа модыг нь хаанаас авчихсан юм бол?

Хариулт:-Хойд Завханы нутаг, Архангайн нутгаас л дандаа үхэр тэргээр ачиж ирсэн гэдэг юм шүү. Дандаа монгол мужаанууд барьсан юм гэнэ лээ.

Асуулт:-Ер нь чулуун суурьтай модон барилгууд л байсан уу?

Хариулт:-Тийм гэнэ лээ.

Асуулт:-Аль овоог тахих вэ? Ямар газар усаа тахих вэ?

Хариулт:-Цагаан давааны энэ талын орой, тэгээд энэ наашаа Мандалт, тийшээ Тэгшбуянт бүгдийг л тахидаг байсан гэж ярьдаг юм.

Асуулт:-Тэр үед хятадууд байсан уу, худалдаачин?

Хариулт:-Энд нэг их хятад байгаагүй гэсэн.

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Наран гэгээний хийд хэзээ тарж нураагдав, лам нар нь яасан юм бол?

Хариулт:-Шинэ эргэлтийн бодлого гараад л тэгээд хүрээ хийд тараад лам нар голдуу хар болж хөдөө гараад тэгж байсан гэж байгаа. Тэгээд 37 оноос арай өмнө юмуу даа тэр хавьд л Наран гэгээнийг эцэгтэй нь Наран гэгээний **хутагтын** хийдийн 13 лам гэдэг байхаа, манай сумын төвийн үрд талын далангийн доод үзүүрийн баруун тийшээ харсан ганга дотор бүгдийг нь бүсээр нь холбож байгаад буудаж алсан юм гэнэ лээ. Тэгэхээр тэр Наран гэгээний эцэг **Дашширчин** гээч хүн бүсээр нь холбосон бол буудахад дээшээ тохой хэртэй хөөрөөд ирэхээр нь тэр ирж цаазалсан үлсүүд хормойноос нь татаж буулгаж байгаад ташаад буудаж алсан гэж тэгж хөгшчүүл ярьдаг юм шүү.

Асуулт:-Сүм хийдийнх нь барилга нь яасан юм бол?

Хариулт:-Сүм хийдийн барилга ер нь тэгсгээд нураагаад хамгийн сүүлд **артелийнхан** гэж манай сумын тэр үлсүүд хойд хүрээнээс үхэр тэргээр татаж буулгаж байсан. Тэгээд энэ төв дээр авчирч барилга барьж байсан гэж артелийн барилга. Гар үйлдвэрийн артель.

Асуулт:-Бурхан шүтээнийг нь яасан юм бол, ном судар?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Ер нь бурхан шүтээн, ном судар хэрэгтэй бүхэн нь энд тэндгүй лам нар нь ганц нэгийг ах дүү садандаа өгсөн үү, үгүй юу тэр үед чинь нуусан ч юмуу даа, ер нь хад, асга рүү хийгээд, зарим нь хүрээний буурин дээр аваачиж байшинд аваачиж байгаад салхинд хийсээд тэгээд үрэгдсэн гэж ярьдаг юм. Гол гол судар, шүтээнүүд нь яасныг би тодорхой мэдэхгүй л байна.

Асуулт:-Ийш тийш нь ачиж яваагүй юу?

Хариулт:-Тийм юм би ерөөсөө дуулаагүй.

Асуулт:-Тус сумын нутагт орших **Хадатын** хийдийн тухай та ярьж өгнө үү?

Хариулт:-**Хадатын** хийд бол их л том хүрээ байсан гэж ярьдаг юм, 100 гаруй ламтай, хамба нь **Балсамбуунамсрай** гэдэг хүн байсан юм гэнэ лээ. Бусад нарийн ширийн юмыг сайн мэдэхгүй байна. Гэхдээ **Хадатын** хүрээн дээр манай аав бүрээчээр ажиллаж байсан гэж ярьдаг юм. Тэр бүрээ нь болохоор 2 метр шахуу урт тийм бүрээ байсан. Тэрний урдур үлээж байхад нь гарахад бүчгүй малгайтай хүний малгай нь хийсээд ойчдог тийм их хүчтэй үлээж байсан гэж тэгж ярьдаг юм байна лээ. Манай аав **Хадатын** хүрээн дээр ламаар шавилан сууж байсан юм.

Асуулт:-Хэн гэдэг хүн ямар цол юутай байсан бэ?

Хариулт:-Манай аав Жамсран гэдэг хүн байсан юм, цол хэргэм юм байхгүй байх. Гэхдээ нэлээн сайн ламын тоонд орж байсан тийм л хүн байсан юм. Манай аавтай цуг Түмэнбаяр гэдэг хүн бүрээ үлээж байсан. Тэр нэлээн тийм **онгируодуу** хүн байсан. Бүрээний урдур хүн гарахаар зэрэг хүчтэй үлээгээд малгайг нь **яачихаар** үгүй мөн **ёнхир байнаа** даа, үгүй мөн донхир **байнаа** гээд их хөхөрдөг байсан юм гэж хуучилдаг байсан юм.

Асуулт:-Хичнээн ламтай байсан юм бол?

Хариулт:-100 гаруй ламтай байсан гэсэн байхаа. Том хүрээ байсан гэдэг юм.

Асуулт:-Дуган хичнээн **байхав**, ямар ямар дугантай юм?

Хариулт:-Лав л тэр **Бажигийн** дуган, ерөнхий том дуган гээд лав л 6, 7 том дуган байсан юм байна лээ.

Асуулт:-Модоор хийсэн үү?

Хариулт:-Голдуу модоор хийсэн, заримыг нь ч туйпуугаар ч хийсэн газар байдаг л юм шиг байна лээ. Монголчууд барьсан байхаа, тэрнийг нарийн сайн мэдэхгүй л байна. Хойд талд нь зүүн хойд талд нь Зүрх гэж уул, бага шиг гозгор шовх байдаг юм, тэрнийг их тахидаг байсан гэдэг юм. **Дүлцэнгийн** шороо, **Даагын** голын урд талд нь **Даагын** голын гээд баруун тийшээ харсан том уулын хажуугаас авсан булаг байдаг юм, тэрний наад тал дээрээс лам нар нь дүүлж байгаад **Дүлцэнгийнгийн** шороогоо тэндээс авдаг байсан гэж ярьдаг юм.

Асуулт:-Гол шүтээнүүд нь юу юм бол?

Хариулт:-Тэрнийг мэдэхгүй.

Асуулт:-Энэ хийд маань хэдэн хүний үед устаж үгүй болов, татан буугдав?

Хариулт:-Энэ ерөөсөө төр эргээд л хүрээ хийд нь тараад лам нар нь хөдөө гарах нь гараад, зарим нь баригдаж явах нь яваад тэгээд хамгийн сүүлийн дуган нь 1953 оны үед ганц дуган байсныг тэрнийг буулгаад төв дээр очиж захиргааны контор барьж байсан тийм л юм даа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Толгой лам нар нь ямар хүн байсан бол, тэд нарыг яасан бол хэлмэгдүүлэлтийн үеэр?

Хариулт:-Ер нь хэлмэгдүүлэлтийн үед чинь толгой лам нарыг голдуу бариад явсан гэсэн шүү.

Асуулт:-Зарим улсуудын нэр усыг мэдэх үү?

Хариулт:-Тэндээс чинь **Бэгзжав гүртэн** гэж Юнрэнгийн Бэгзжав гэж хүн **гэсгүй** байсан юм гэнэ лээ, тэр хүнийг л бариад явсан гэж явдаг юм шүү. Манай хадам эцгийн төрсөн ах нь байсан юм гэнэ лээ. Бэгзжав гэдэг. Тэрнийг нь **Хадатын** хүрээний **гэсгүй** байсан юм гэсэн. 30 хэдэн хүнийг **бариад**, хоёр хүн ирээд морь унуулаад хөтлөөд явсан гэж ярьдаг юм, тэгээд л сураггүй алга болсон. Үлдсэн хөрөнгийг нь 2 дахин хураасан гэж байгаа юм, тэгээд л тэр айл тэгээд дууссан. Ар гэрийнхэн нь хичнээн жил хараад яасныг нь мэдэхгүй байсан. Одоо энэ хэлмэгдэлтийн үед цагаан номонд нэр овог нь гарч байсан гэж эмээ тэгж ярьдаг юм.

Асуулт:-Одоо та тус сумын нутагт байсан Бугатын хийдийн тухай ярьж өгнө үү?

Хариулт:-Манай сумын нутгийн зүүн хойд талаар байгаа Бугатын хүрээ гэдэг бол энэ Гурванбулагийн Билүүтийн хүрээний харьяат гээд Бугатын хурал гэдэг нэртэй байсан юм байна лээ. Нэлээн тийм цөөвөр ламтай, их цомхон хүрээ байсан гэж ярьдаг юм. Тэр хамба нь **Жижлээ ренбүүчий** гэж **Суурьбазар** гэдэг хүн байсан гэдгийг мэднэ. Бусдыг сайн тодорхой мэдэхгүй байна. Хамгийн сүүлд тэнд хүрээний буурин дээр үлдсэн лам нь Сундуйгилсай гэж нэг хүн байсан. Тэр хүн 50-иад оны үед амьтан уруудаад яахаар ганцаараа жижигхэн гэртээ хоцордог, өвөлждөг, хавар хамаг амьтан хүрээд ирэхэд тэндээ байж байдаг. Тийм лам байж байгаад 50 он дөнгөж гарсан уу, үгүй юу тэгээд урагшаа яваад өгч байсан. Бугатын хүрээний тухай товчхондоо ийм л юм байна.